




НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2020/04

ᠨᠠᠯᠠᠶᠢᠬᠡ ᠳᠦᠦᠷᠭᠡᠢ ᠨᠢᠶ᠎ᠠ ᠵᠠᠰᠠᠭ ᠨᠢᠶ᠎ᠠ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠤᠰ



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2019 ОН	2
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	7
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	8
 ЭРҮҮЛ МЭНД	9
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	11
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	12
 ГЭМТ ХЭРЭГ	12
 ТӨСӨВ	14
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	14
 АЖ ҮЙЛДВЭР	15
 МАЛ АЖ АХУЙ	17
 ХАРИЛЦАА ХОЛБОО	18
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	18



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	36 425	36 911	37 608	37 715	-
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	891	305	157	260	201
Үүнээс: эмэгтэй	тоо	525	152	88	129	89
Шинээр төрсөн хүүхэд	тоо	256	241	277	292	284
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	470	196	160	160	138
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	164	123	171	127	120
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	6 102.5	6 280.9	6 678.4	8 068.1	9 056.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	5 646.5	5 494.3	5 899.2	8 454.9	8 400.1

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт 2. Дүүргүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын харьцуулсан үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2019 оны IV сард				2020 оны IV сард					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	309	Баянгол	7 739	Налайх	55	314	Баянгол	7 687	Налайх	55
			Чингэлтэй	1 771	Багануур	48		Чингэлтэй	1 702	Багануур	46
			Сүхбаатар	700	Багахангай	32		Сүхбаатар	701	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	79	Багахангай	476	Налайх	67	68	Багахангай	576	Баянзүрх	53
			Багануур	143	Хан-Уул	53		Багануур	114	Налайх	51
			Баянзүрх	114	Сонгинохайрхан	44		Баянгол	102	Сонгинохайрхан	41
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Налайх	21	Баянгол	9	11	Чингэлтэй	12	Сүхбаатар	5
			Баянзүрх	14	Хан-Уул	6		Сонгинохайрхан	11	Хан-Уул	5
			Чингэлтэй	13	Багахангай	-		Багануур	10	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	53	Баянзүрх	66	Багануур	39	40	Багануур	38	Сүхбаатар	24
			Чингэлтэй	47	Сонгинохайрхан	39		Баянзүрх	37	Хан-Уул	22
			Хан-Уул	45	Багахангай	7		Сонгинохайрхан	37	Багахангай	7
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	91	Сүхбаатар	106	Налайх	14	78	Сүхбаатар	63	Багануур	10
			Чингэлтэй	62	Багануур	11		Чингэлтэй	62	Налайх	8
			Хан-Уул	44	Багахангай	7		Хан-Уул	40	Багахангай	7
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	93	Сүхбаатар	137	Налайх	53	68	Сүхбаатар	114	Хан-Уул	49
			Чингэлтэй	110	Багануур	37		Баянгол	77	Налайх	48
			Баянгол	104	Багахангай	35		Чингэлтэй	75	Багануур	29

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2020 оны IV сарын танилцуулга



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажилгүй иргэдийн тоо 2020 оны 4 сард 201, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59 хүнээр (22.7%) бүүрсан ба 44.3 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 28.4 хувь нь 15-24 насны залуучууд, 34.3 хувь нь 25-34 насныхан, 22.4 хувь нь 35-44 насныхан, 11.9 хувь нь 45-54 насны, 2.5 хувь нь 55-59 насныхан, 0.5 хувь нь 60-с дээш насныхан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн IV сард

Үзүүлэлт	2017 IV		2018 IV		2019 IV		2020 IV	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	305	152	157	88	260	129	201	89
Насны бүлгээр:								
15-24	69	27	19	8	31	19	57	30
25-34	109	52	60	29	91	48	69	34
35-44	73	47	43	32	75	32	45	12
45-54	42	21	27	17	42	21	24	12
55-59	10	3	6	1	17	7	5	-
60 +	2	2	2	1	4	2	1	1
Үүнээс : Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	8	2	3	1	4	2	4	2

Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн IV сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2017 IV	2018 IV	2019 IV	2020 IV	2017 IV	2018 IV	2019 IV	2020 IV
Ажилгүйчүүд, бүгд	305	157	260	201	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	2	-	4	1	0.7	-	1.5	0.5
Дипломын болон бакалавр	40	40	51	38	13.1	25.5	19.6	18.9
Тусгай мэргэжлийн дунд	15	3	19	5	4.9	2.0	7.3	2.5
Техникийн болон мэргэжлийн	47	22	34	19	15.4	14.0	13.1	9.4
Бүрэн дунд	175	79	123	118	57.4	50.3	47.3	58.7
Суурь	20	12	22	16	6.5	7.6	8.5	8.0
Бага боловсрол	3	1	4	2	1.0	0.6	1.5	1.0
Боловсролгүй	3	-	3	2	1.0	-	1.2	1.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2020 оны эхний 4 сард шинээр төрсөн 311 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 75 хүнийг бүртгэлээс хасаж, 46 гэрлэлт, 11 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 хүүхдээр (6.5%) өссөн, нас баралт өмнөх оны мөн үеэс 7 (8.5%) буурсан байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 51.4 хувь нь хүү, 48.6 хувь нь охин байна. Нийт нас баралтын 62.7 хувь нь эрэгтэй, 37.3 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 5. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт		2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Төрсөн хүүхэд, бүгд		256	241	277	292	311
Үүнээс:	Эрэгтэй	124	135	143	149	160
	Эмэгтэй	132	106	134	143	151
Нас баралт, бүгд		89	77	77	82	75
Үүнээс:	Эрэгтэй	56	46	51	60	47
	Эмэгтэй	33	31	26	22	28

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 6. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүн, насны бүлгээр, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2018 I-IV			2019 I-IV			2020 I-IV		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	Эмэгтэй
Нийт	162	81	81	128	64	64	92	46	46
18-19	-	-	-	-	-	-	1	-	1
20-24	38	13	25	24	8	16	7	3	4
25-29	58	30	28	41	19	22	26	11	15
30-34	33	19	14	25	17	8	34	19	15
35-39	9	6	3	14	8	6	10	5	5
40-44	7	4	3	9	4	5	2	1	1
45-49	6	4	2	10	5	5	9	6	3
50 +	11	5	6	5	3	2	3	1	2

2020 оны эхний 4 сард гэрлэлтээ баталгаажуулсан 46 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 (28.1%) буурсан байна. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 1.1% нь 18-19 насны, 7.5% нь 20-24 насны, 28.3% нь 25-29 насны, 37.0% нь 30-34 насны, 10.8% нь 35-39 насны, 2.2% нь 40-44 насны, 9.8% нь 45-49 насны, 3.3% нь 50-аас дээш насныхан байна.

Хүснэгт 7. Гэр бүл цуцлалт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт		2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Гэр бүл цуцлалт, бүгд		22	20	21	23	11
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	-	2	-	2	-
	1-3	-	3	-	-	-
	4-6	-	2	3	2	-
	7-9	8	4	5	3	-
	10-14	6	6	6	11	9
	15-19	2	2	-	2	2
	20 ба түүнээс дээш	6	1	7	3	-

2020 оны эхний 4 сард нийт 11 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 81.2% нь 10-14 жил, 18.8% нь 15-19 жил ханилсан хосууд байна.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 (52.2%) буурсан байна.

Дүүрэгт 2020 оны эхний 4 сард үрчлэгдсэн 3 эрэгтэй, 5 эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 8. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд	2	7	-	2	8
Үүнээс: насны бүлгээр					
3 хүртэл	1	7	-	1	4
3-6	1	-	-	1	1
7-9	-	-	-	-	1
10 ба түүнээс дээш	-	-	-	-	2

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2020 оны эхний 4 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2915.3 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын сангаас 2020 оны эхний 4 сард 23833 даатгуулагч иргэнд 9376.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.


Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2019 I-IV		2020 I-IV		Даатгуулагчдын тоо	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Тоо	Өсөлт, бууралт хувь
Нийт орлого	-	2 984.1	2 915.3		-	-
Нийт зардал	21 541	8 284.4	23 833	9 376.3	2 292↑	10.6↑
Тэтгэврийн даатгалын сан	19 164	7 035.6	21 620	8 029.8	2 456↑	12.8↑
Өндөр насны тэтгэвэр	13 290	4 857.1	13 891	5 558.3	601↑	4.5↑
Тахир дутуугийн тэтгэвэр	2 947	830.6	4 717	977.2	1 770↑	60.0↑
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1 177	327.8	1 187	367.9	10↑	0.8↑
Цэргийн тэтгэвэр	1 750	1 020.1	1 825	1 126.3	75↑	4.3↑
ҮОМШӨ-ний даатгалын сан	1 845	888.5	1 713	896.1	-132↓	-7.1↓
Тахир дутуугийн тэтгэвэр	1 652	839.9	1 592	852.2	-60↓	-3.6↓
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	112	44.4	96	41.1	-16↓	-14.3↓
Сувиллын зардал	78	3.3	23	2.1	-55↓	-2.3д↓
ҮОМШӨ ХЧТА ¹	2	0.7	2	0.6	0	0
Төлбөр, зардал	1	0.2	-	-	-1↓	-100↓
Тэтгэмжийн даатгалын сан	475	271.2	420	305.1	-55↓	-11.6↓
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	256	28.3	202	28.2	-54↓	-21.1↓
Жирэмсний амралт	159	182.9	149	207.8	-10↓	-6.3↓
Оршуулга	60	60.0	69	69.0	9↑	15.0↑
Ажилгүйдлийн даатгалын сан	57	89.1	80	145.1	23↑	40.3↑
Ажилгүйдлийн тэтгэмж	57	89.1	80	145.1	23↑	40.3↑

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас 2020 оны эхний 4 сард 21620 тэтгэвэр авагч иргэдэд 8029.8 сая төгрөг олгосон байна. Олгосон нийт тэтгэврийн 69.2 хувийг өндөр насны, 12.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.6 хувийг тэжээгчээ алдсан, 14.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2020 оны 4 сард давхардсан тоогоор нийт 17860 иргэнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн сангийн зарцуулалт өссөн дүнгээр 2025.6 сая төгрөгт хүрчээ.

Хүснэгт 10. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2019		2020		2020% 2019	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	IV	I-IV	IV	I-IV	I-IV	I-IV
Халамжийн орлого, бүгд	-	2 095.4		2 123.6	28.2↑	1.3↑
Зарцуулалт, бүгд	4 849	2 007.1	17 860	2 025.6	18.5↑	0.9↑
Халамжийн тэтгэвэр	435	530.3	611	598.1	67.8↑	12.8↑
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	465	175.6	725	231.3	55.7↑	31.7↑
Ахмад настны хөнгөлөлт	30	71.2	374	99.9	28.7↑	40.3↑
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	48	25.5	697	41.1	15.6↑	61.2↑

Хүснэгт 10-ын үргэлжлэл

Үзүүлэлт	2019		2020		2020% 2019	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	IV	I-IV	IV	I-IV	I-IV	I-IV
Алдарт эхийн одонгийн тусламж	449	351.0	2 594	349.2	-1.8↓	-0.5↓
Алдар цолтой ахмад настнуудад олгосон	13	9.9	13	10.1	0.2↑	2.0↑
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	-	221.3	6 688	314.2	92.9↑	42.0↑
Амьжиргааг дэмжих зөвлөл	-	1.6	1 520	97.1	95.5↑	5.9д↑
Насны хишгийн зардал	1 200	134.5	1 800	141.5	7.0↑	5.2↑
Цалинтай ээж хөтөлбөр	1 457	326.6	2 700	74.2	-252.4↓	-3.4д↓
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	165	74.2	8	10.8	-63.4↓	-5.8д↓
Өрх толгойлсон эцэг эхийн хөтөлбөр	-	38.0	130	57.3	19.3↑	50.8↑
Бусад зардал	-	0.5	-	-	-0.5↓	-100.0↓

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ЭРҮҮЛ МЭНД

2020 оны эхний 4 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 15 (5.3%) өссөн, нас баралт 9 (9.7%) буурсан байна.

Хүснэгт 11.Төрөлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Амаржсан эхийн тоо, бүгд	254	232	277	283	298
Амьд төрсөн хүүхэд	254	235	281	284	301
Амьгүй төрсөн	4	3	3	2	1
Эхийн эндэгдэл	-	-	-	-	1
Нас баралт	69	81	80	93	84
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	5	1	6	3
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	15	4	7	10	5
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	45	64	59	63	60
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	9	13	14	20	19

2020 оны эхний 4 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 71.4 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 22.6 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 6.0 хувь хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

Хүснэгт 12. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Нийт халдварт өвчин	470	196	160	160	138
Хурц халдварт өвчин:	271	76	69	48	22
Хепатит В вирус	2	-	1	1	1
Хепатит С вирус	-	1	-	1	-
Халдварт шар	-	-	-	-	-
Менинжет	-	-	1	1	-
Салхин цэцэг	18	9	39	25	13
Гахайн хавдар	-	-	-	-	-
Паротит	-	-	1	3	1
Бруцеллез	-	-	-	2	-
Ёлом	-	-	-	1	1
Дизентери	-	4	5	2	-
Гар, хөл, амны өвчин	10	57	12	9	2
Хоолны хордлого	-	-	-	-	-
Сальмонеллэз	2	-	1	-	-
Улаан эсэргэнэ	-	4	1	2	4
Эритема	-	-	2	-	-
Хумхаа	-	-	2	-	-
Бүслүүр үлд	-	-	-	-	-
Экзантема сабитум	-	-	1	-	-
Хачигт броллез	-	-	-	1	-
Улаан бурхан	239	-	-	-	-
Сүрьеэ	27	15	14	23	19
Арьс өнгөний өвчин	172	105	77	89	97
Тэмбүү	49	22	27	24	28
Үүнээс: төрөлхийн	-	-	-	-	-
Заг хүйтэн	20	19	17	19	33
Хамуу	-	-	-	-	-
Бэлгийн замын мөөгөнцөр	-	39	13	21	20
Мөөгөнцөр	43	5	-	-	-
Трихомониаз	60	20	20	25	16

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд хурц халдварт өвчнөөр 22 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 (54.2%) хүнээр буурч, арьс өнгөний өвчлөл 97 гарсан нь 8 (9.0%) хүнээр өсч, сүрьеэгээр 19 хүн өвчилсөн нь 4 (17.4%) тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний гаралт 138 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 (13.7%) буурсан байна.

Хүснэгт 13. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Урьдчилан сэргийлэх тарилга	2 093	2 074	1 901	2 043	2 216
Амбулаторын үзлэг	63 600	61 445	71 939	60 147	59 308
Ор хоног	17 676	16 542	20 093	19 584	16 782
Эмчийн тоо	69	68	75	78	76
Сувилагчийн тоо	104	95	98	105	108
Орны тоо	165	177	227	227	227

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 839 (1.4%), ор хоног 2802 (14.3%) тус тус буурсан байна. Урьдчилан сэргийлэх тарилга 173 (8.5%) өссөн байна.



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2020 оны эхний 4 сард олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хоргилсонтой холбогдуулан мэдээ гараагүй болно.

Хүснэгт 14. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, 2020 оны эхний IV сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн ³ үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	-	-	-	-	-	-	-	-

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон

³ Орон нутаг судлах танхим



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2020 оны эхний 4 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 97.0 сая төгрөг болж, орлогын 37.9 хувийг орон сууц, 40.0 хувийг гэр хороолол, 22.1 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 5.9 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 15. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	86.3	86.8	97.0	36.8	38.7	21.5
Хог тээвэрлэлт, мянган тонн	28.8	18.1	5.9	1.4	3.7	0.8

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 16. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Шахсан ус	мянган м ³	430.8	308.8	351.4	313.7
Борлуулсан ус	мянган м ³	187.5	132.8	289.4	166.7
Үүнээс: Хүн амд	мянган м ³	116.2	86.2	171.0	102.3
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м ³	71.3	46.6	118.4	64.4
Татан зайлуулсан бохир	мянган м ³	175.4	129.3	201.0	122.9
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	204.7	157.2	350.0	255.8
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	126.4	128.4	191.7	127.1
Халаалтын орлого	сая төгрөг	74.2	73.7	116.3	126.4

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2020 оны эхний 4 сард дүүргийн хэмжээнд 166.7 мянган м³ ус борлуулснаас, 102.3 мянган м³ (61.3%) усыг хүн амд, 64.4 мян.м³ (38.7%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.



ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэгт 2020 оны эхний 4 сард 120 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 гэмт хэргээр (5.5%) бүүрч, гэмт хэргийн илрүүлэлт 28.8 хувьтай байна.


Бүртгэгдсэн гэмт хэрэгт 39 сэжигтэн яллагдагч холбогдсоныг насны ангиллаар авч үзвэл, 16-17 насны 1 (2.5%), 18-24 насны 7 (17.9%), 25-29 насны 6 (15.4%), 30-34 насны 8 (20.5%), 35-39 насны 6 (15.4%), 40-44 насны 5 (12.8%), 45-49 насны 4 (10.3%), 50-54 насны 2 (5.2%), иргэд байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт		2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		123	171	127	120
Хүн амины	Санаатай	1	1	1	1
	Учрал	8	7	7	3
	Бусдыг болгоомжгүй алах	-	-	-	-
-Хүчин		2	1	3	-
Дээрэм		1	3	1	-
Танхай		10	-	-	-
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		-	3	-	1
Хулгай	Иргэдийн өмчийн	27	67	29	24
	Малын	-	4	7	6
	Халаасны хулгай	-	1	-	-
	Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	-	-	-	-
	Автомашины	2	2	-	1
Залилан		6	7	15	22
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		41	45	43	46
Авто тээвэр		3	6	6	2
Бусад		22	21	12	13
Хэрэгсэхгүй болгож мэдээнээс хасагдсан хэрэг		-	-	-	-
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо		41	140	88	79
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь		68.2	19.3	25.4	28.8
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		108	38	38	39
Үүнээс:	Ажилгүй	80	24	26	29
	Албан хаагч	4	4	2	
	Сурагч	4	-	-	
	Оюутан	1	4	-	1
	Малчин	1	-	1	
	Тэнэмэл иргэд	-	-	-	
	Төрийн бус байгууллагын ажилтан	1	-	2	2
	Хугацаат цэргийн алба хаагч	-	-	-	
	ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	17	6	7	5
	Хоригдол				2
Эрүүлжүүлэгдсэн хүн		1065	1066	1047	1455

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 48 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 934.8 сая төгрөгийн хохирол учруулсны 504.9 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2020 оны эхний 4 сард 10057 зөрчил илрүүлж, 9482 хүн, 1 хуулийн этгээдийг 254.4 сая төгрөгөөр торгож, 1455 (эмэгтэй 199) иргэнийг эрүүлжүүлж, 84 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 35 иргэнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.




ТӨСӨВ

2020 оны эхний 4 сард дүүргийн төсөвт 698.7 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 285.0 сая төгрөгөөр (29.0%) тасалдсан үзүүлэлттэй байна.

Татварын орлогын 42.3 хувийг хүн амын орлогын албан татвар, 14.0 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 3.7 хувийг түгээмэл тархацтай амнат, 0.3 хувийг бууны татвар, 6.1 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 5.9 хувийг хүү торгуулийн орлого, 0.3 хувийг ус рашаан ашигласны татварын орлого, 27.4 хувийг Татварын бус торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 5.Орон нутгийн татварын орлого бүрдэлт



Эх үүсвэр: Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 10000 төгрөгөөр (1дахин) өссөн, адууны шир 2000 төгрөгөөр (16.7%), үхрийн шир 6000 төгрөгөөр (46.1%), Ямааны ноолуур 70000 төгрөгөөр (56.0%) тус тус буурсан байна.

Хүснэгт 18. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн IV сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2016 IV	2017 IV	2018 IV	2019 IV	2020 IV
		төгрөг				
Тэмээний шир	ширхэг	22 000	20 000	30 000	10 000	20 000
Адууны дэл	кг	3 000	-	-	8 000	4 000
Адууны сүүл	кг	8 000	-	-	12 000	8 000
Адууны шир	ширхэг	15 000	20 000	15 000	12 000	10 000
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	22 500	27 500	25 000	13 000	7000
Хонины ноостой нэхий	ширхэг	-	3 500	2 000	1 500	-
Ямааны ноолуургүй арьс	ширхэг	-	500	-	500	-
Ямааны ноолуур	килограмм	60 000	58 000	85 000	125 000	55 000

Хүснэгт 19. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2019.IV.24					2020.IV.29				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 630	1 660	2 195	-	-	1 370	1 460	2 000	-
Петровис	2 235	1 690	1 785	2 335	-	2 000	1 450	1 490	2 150	-
Магнай трейд	2 235	1 690	1 780	2 330	-	2 000	-	1 500	2 150	-
Сод монгол	2 180	-	1 735	2 280	-	2 000	-	1 490	2 150	-
Шунхлай	2 245	1 700	1 785	2 335	-	2 000	-	1 500	2 150	-
Юнигаз	-	-	-	-	1 300	-	-	-	-	1 020
Дундаж үнэ	2 224	1 678	1 749	2 295	1 300	2 000	1 410	1 488	2 120	1 020

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ 2020 оны IV сард



АЖ ҮЙЛДВЭР

2020 оны эхний 4 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 0.2 хувьтай, цахилгаан эрчим хүч 7.0 хувиар, усан хангамж 45.5 хувиар, тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 6.0% , цахилгаан эрчим хүч 10.4%, усан хангамж 1.1% хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая төгрөг		
		2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Эрчим хүчний үйлдвэр:							
Цахилгаан	сая.квт.цаг	39.7	43.9	40.8	6 053.6	6 757.1	7 459.6
Дулаан	мянган гкал	53.1	42.2	42.1	1 898.3	1 788.1	1895.9
Усан хангамж	мянган м ³	685.6	621.5	313.7	181.7	164.9	166.7
Олборлох үйлдвэр:							
Шохойн чулуу	тонн	-	3.7	-	-	32.0	-
Нүүрс	мянган тонн	0.25	-	-	14.6	-	-
Хайрга	мянган м ³	-	-	1.5	-	-	24.0
Элс	мянган м ³	5.6	4.65	3.2	41.4	33.8	29.0
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	мянган ширхэг	83.8	1 342.0	812.5	11.6	447.1	256.2
Цемент	мянган тонн	5.8	5.84	3.385	732.8	893.4	430.8
Оёдол	мянган ширхэг	10.5	31.5	0.3	94.0	612.7	6.3
Гэр ахуйн оёмол эдлэл	мянган ширхэг	2.2	0.6	0.5	21.7	16.7	14.8
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мянган ширхэг	21.9	21.2	2.2	98.4	108.5	19.9
Модон эдлэл	сая.төг	-	2.3	-	-	2.3	-
Замаска	тонн	55.2	20	9.5	14.4	5.0	2.4
Барилгын шавардлагын хар замаска	тонн	75.1	25	25	19.5	7.5	7.5
Плитаны цавуу	тонн	36.5	10	35.3	12.1	3.4	12.0
Резинэн эдлэл	сая төгрөг	-	-	-	-	-	-
Хэвлэлийн будаг	мянган ширхэг	11.1	5.5	5.9	177.5	120.4	157.5
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:							
Талх	тонн	14.3	15.32	9.6	27.2	31.2	19.3
Нарийн боов, жигнэмэг	тонн	6.4	18.5	6.45	12.3	34.2	12.0
Хэрчсэн гурил	тонн	0.3	-	-	0.3	-	-
Эмчилгээний цай	килограмм	-	905	-	-	29.6	-
Гүзээний чипс	тонн	-	0.02	-	-	0.7	-
Утсан чанасан болон хагас боловсруулсан мах	тонн	-	85.2	250	-	622.3	1 785.5
Өлөн гэдэс	мянган гогцоо	-	40.0	-	-	720.0	-
Борц	тонн	-	0.5	-	-	20.2	-
Элэгний нухаш	тонн	-	0.9	-	-	4.5	-
Цэвэр ус	мянган литр	-	1 465.0	316.8	-	242.2	61.5

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр



МАЛ АЖ АХУЙ


2020 оны эхний 4 сард 9894 хээлтэгч малаас 9900 төл гарснаас 455 төл мал хорогдож, 9445 төл бойжиж, төл бойжилт 95.4 хувьтай байна. Бойжсон нийт төлийн 4.3 хувийг унага, 17.7 хувийг тугал, 54.1 хувийг хурга, 23.9 хувийг ишиг эзэлж байна. Дүүргийн хэмжээнд мал төллөлт 37.8 хувьтай байна.

Хүснэгт. 21 Мал төллөлт, том малын хорогдол малын төрлөөр


Үзүүлэлт / төрөл	2020 I-IV					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Төллөсөн хээлтэгч	9 894	-	410	1 710	5 262	2 512
Гарсан төл	9 900	-	410	1 710	5 263	2 517
Хорогдсон төл	455	-	7	36	149	263
Бойжсон төл	9 445	-	403	1 674	5 114	2 254
Бойжилтын хувь	95.4	-	98.3	97.9	97.2	89.5
Хорогдсон том мал	607	-	8	81	270	248
Хорогдсон хээлтэгч	383	-	1	33	180	169

Эх үүсвэр : Хороодын сар бүрийн мал төллөлт, хорогдлын мэдээний нэгдсэн дүн

Зураг 7. Том малын зүй бусын хорогдол хороодоор



Зураг 8. Гарсан төл хороодоор



Эхний 4 сарын байдлаар том малын зүй бус хорогдлоор 5-р хороонд 441 (72.7%) буюу хамгийн их, 4-р хороонд хамгийн бага буюу 1 (0.2%) малын хорогдол бүртгэгдсэн байна.

Малын төрлөөр авч үзвэл хонь хамгийн их буюу 270 (44.5%) хорогдож, 8 (1.3%) буюу адуу хамгийн бага, үхэр 81 (13.3%), ямаа 248 (40.9%) хорогдсон байна.



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 86.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 42.3 сая төгрөг (48.9%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 80 (13.2%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 414 (60.3%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 204 (29.7%) нь төсвийн байгууллагад, 69 (10.0%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 22. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Нийт орлого	сая төгрөг	69.9	72.6	83.7	86.4
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	34.3	35.5	41.0	42.3
Телефон цэг	тоо	545	574	607	687
Үүнээс: айл өрх	тоо	303	321	340	414
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	6 640	1 618	1 835	400
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	332	242	459	94
Таксофон	тоо	1	1	1	1

Эх үүсвэр: Налайх дүүргийн холбооны газар

Хүснэгт 23. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт/он	хэмжих нэгж	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
КТВ-ийн орлого	мян.төг	56 651.1	57 325.0	23 090.3	20 841.9
Хэрэглэгч	тоо	3 140	3 575	3 650	1 100



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2020 оны эхний 4 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 98 аж ахуйн нэгж, байгууллагад 303 зөрчил илрүүлэн, 213 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 18, мэдэгдэл 32, зөрчлийн тэмдэглэл 9, дүгнэлт 5, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 41 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 16 дуудлагаар ажиллаж, 312.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 24. Гал түймрийн дуудлагын тоо, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017-I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
Бүгд		29	28	26	16
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	тоо	-	4	2	-
Хувийн өмч	тоо	24	24	22	15
Аж ахуйн нэгж	тоо	5	-	2	1
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	-	-	-
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	хүүхэд	-	-	-	-
	том хүн	-	1	-	-
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	-	-	-	-
	том хүн	1	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	4	8	3	2
Гэр	тоо	3	7	1	3
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-
Хог, хогийн суваг	тоо	7	-	4	3
Машин техник	тоо	3	3	3	4
Барилга байгууламж	тоо	6	2	2	1
Малын хашаа саравч	тоо	1	-	1	-
Бусад	тоо	-	-	-	3
Шалтгаан:					
Цахилгааны	тоо	2	1	1	1
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	3	-	-	5
Лаа, тамхи, шүдэнз	тоо	-	6	3	-
Пийшин зуухны цонолт	тоо	1	-	-	-
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	2	1	-	3
Машин, техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	тоо	-	-	-	-
Архидан согтуурснаас	тоо	2	1	-	-
Газрын тосны бүтээгдэхүүний ашиглалтын буруугаас	тоо	1	-	-	-
Технологийн горим зөрчсөнөөс	Тоо	-	-	-	-
Бусад	Тоо	5	-	-	1
Шалтгаан тогтоогдоогүй	Тоо	14	19	22	6
Аварсан эд хөрөнгө:					
Хүн	тоо	-	1	-	-
Өвөл зуны сууц	тоо	4	4	4	3
Гэр	тоо	1	2	-	1
Барилга байгууламж	тоо	1	1	1	1
Машин техник	тоо	-	2	1	4
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	-	-	-	-
Малын хашаа саравч	тоо	-	-	-	-
Эд хөрөнгө	сая төгрөг	921.0	112.0	200.0	312.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

2020 оны эхний 4 сард дүүргийн Засаг даргын 21 захирамжаар нийт 596 иргэн, 18 аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 25. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, 2020 оны эхний IV сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	-	1	12	5	-	-	1	2

Эх үүсвэр: Газрын алба



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2020 оны эхний 4 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 456 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 435 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа 21 санал хүсэлт байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 95.0 хувьтай. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 431 (94.5%) нь бичгээр, 25 (5.5%) нь тусгай дугаар болон гар утасны аппликейшн үйлчилгээгээр хандсан байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

www.ubstat.mn

Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот